



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
МАТЕМАТИК, ТООН ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЕМИНАР

2020 оны 1 сарын 17, Баасан гараг, 14:00 цаг,
Академич Б.Чадраагийн нэрэмжит танхим /Өрөө 320/

Докторант Э.Нарантуяа /ШУТИС/

МХТ-ийн хөгжлийн үзүүлэлтийг энтропид тулгуурлан тодорхойлох боломжийн судалгаа

Судалгааны ажлын товч танилцуулга: Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХТ) хурдацтай хөгжилтэй холбоотойгоор нийгмийн бүх салбарын хүрээнд болж буй шинэчлэлт, өөрчлөлт, шинэ ойлголт, хөгжлийн үзүүлэлтүүдийг судалж боловсруулах, ашиглах хэрэгцээ шаардлага гарсаар байна. Улс орнуудын МХТ-ийн статистик мэдээ цуглуулах арга, туршлага сайжирч, бодлогын асуудал нь улам бүр боловсронгуй болох тусам салбарын хөгжлийн үзүүлэлтүүд өөрчлөгдөн шинэчлэгдэж хуучин нь хасагдаж, шинэ үзүүлэлтүүд нэмэгддэг учраас МХТ-ийн үзүүлэлтүүдийг тасралтгүй хөгжүүлж, шинэчлэн сайжруулах шаардлага байдагтай холбоотойгоор МХТ-ийн үзүүлэлтүүдэд үнэлгээ хийх үзүүлэлтүүдийг тодорхойлон судлах нь зайлшгүй чухал юм. Судалгааны ажлын зорилго нь мэдээллийн энтропид тулгуурлан МХТ-ийн хөгжлийн үзүүлэлтүүдийг тодорхойлох. Үүнтэй холбоотойгоор МХТ-ийн хөгжлийн үзүүлэлтүүдийг судалж, тэдгээрийн харьцуулсан үнэлгээ хийх, Мэдээллийн тоон хэмжээний тодорхойломж тэдгээрийн хоорондын харилцан хамаарлыг судлах, МХТ-ийн үндсэн үзүүлэлтүүдийн тодорхойлох алгоритм, аргачлалыг боловсруулах зорилтуудтай.

Судалгааны ажлын шинэлэг тал: МХТ-ийн үзүүлэлтүүдийг улс орнуудын МХТ-ийн хөгжлийн индексийг тодорхойлоход хэрэглэгддэг үзүүлэлтүүдээр энтропийн жингийн арга болон хөгжлийн ялгаатай үе шатуудын тархалтын арга ашиглан МХТ-ийн үзүүлэлтийн үнэлгээний үр дүн, гол коэффициентуудыг гаргах аргачлалыг санал болгосон. МХТ-ийн хөгжлийн үзүүлэлтүүдийг нийслэл болон аймаг тус бүрээр болон МХТ-ийн хөгжлийн үзүүлэлт тус бүрээр судалж, тэдгээрийн харьцуулалтыг хийсэн.

Практик ач холбогдол: МХТ-ийн хөгжил, дэвшилд тулгуурлан улс орныг хөгжүүлэхэд салбарын дэд бүтэц, түүний хүртээмж, хэрэглээ, хөгжлийн үзүүлэлтийг тодорхойлох, мэдээллийн технологийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг тооцох, статистик мэдээ, өгөгдөл цуглуулах, харьцуулсан судалгаа, хяналт-шинжилгээ хийж үнэлж дүгнэхэд чухал ач холбогдолтой.

Судалгааны арга зүй: Мэдээллийн тоон хэмжээний тодорхойломж тэдгээрийн хоорондын харилцан хамаарал, мэдээллийн энтропи, түүний хэрэглээг судлан, энтропийг 5 шинжээр харьцуулалт хийсэн. Мөн энтропийн хөгжлийн талаар хийсэн судалгааны ажлуудыг харьцуулан харьцуулалтын аргыг хэрэглэсэн.